



**ВЕЙР МИНЕРАЛС МОНГОЛИА ХХК**

УЛААНБААТАР ХОТ, БАЯНГОЛ ДҮҮРЭГ, 29-Р ХОРОО, АЖИЛЧДЫН ГУДАМЖИД  
БАЙРЛАХ МЕТАЛЛ ХИЙЦИЙГ РЕЗИНЭН ХУЯГААР ДОТОРЛОХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
ТӨВИЙН

**2026 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ  
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

## ОРШИЛ

“Вейр Минералс Монголиа” ХХК нь Шотландын “Вейр Групп”-ын салбар компани бөгөөд 2012 онд байгуулагдсан. Тус компани нь уул уурхайн тоног төхөөрөмжийн импорт, дотоод худалдаа, зуучлал, агуулахын үйл ажиллагаа эрхэлдэг. Австрали, АНУ зэрэг өндөр хөгжилтэй орнуудад өргөн хэрэглэгддэг сүүлийн үеийн технологийг ашиглан уул уурхайн баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмж, шугам хоолойн зэврэлт, элэгдэлт, химийн бодисын үйлчлэлийг тэсвэрлэх, эдэлгээг удаашруулах зорилгоор металл хийцийг резинэн хуягаар доторлох үйлчилгээг 2017 оноос эхлэн үзүүлж байна.

Төсөл хэрэгжүүлэгч нь 2018 болон 2022 онд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, 2022 онд 5 жилийн хугацаатай байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулсан. Уг төлөвлөгөөг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/618 дугаар тушаалаар батлагдсан аргачлалын дагуу боловсруулсан болно.

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ (БОННУ)-ний гол зорилго нь төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэнд, нийгэмд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, химийн бодисын эрсдэл, аюул ослыг тодорхойлж, эдгээр сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний зөвлөмж боловсруулах явдал юм. Мөн 2022-2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулахад чиглэгдсэн.

Үнэлгээг үйл ажиллагааны шат дамжлага бүрт хийж, түүний үр дүнд үндэслэн байгаль орчин болон хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээг байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан болно.

Төсөл хэрэгжүүлэгч нь төслийн үйл ажиллагааны явцад байгаль орчин болон хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, осол, эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор энэхүү Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд тусгагдсан заавар, зөвлөмж, эрсдэлийг менежментийн төлөвлөгөөг баримтлан ажиллана. Үүнтэй уялдуулан сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхдээ холбогдох хууль, дүрэм, журам болон стандартыг чанд мөрдөн ажиллах болно.

## 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 1.1 Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн, нэгж байгууллага

#### ХҮСНЭГТ 1.1 ТӨСЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Төсөл хэрэгжүүлэгчийн нэр	“Вейр Минералс Монголиа” ХХК
Төслийн нэр	“Металл хийцийг резинэн хуягаар доторлох үйлчилгээний төвд ашиглагдах химийн бодисыг импортлох, ашиглах, хадгалах, худалдах” төсөл
Регистрийн дугаар	5628083
Улсын бүртгэлийн дугаар	9019065008
Хаяг	Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 29-р хороо, Ажилчдын гудамж, 178
Утас	75774297, 95589009
Ажиллах хуваарь	Жилийн турш тасралгүй
Талбайн хэмжээ:	Засвар үйлчилгээний төв 1440 м <sup>2</sup> Агуулах 800 м <sup>2</sup> Оффис 217 м <sup>2</sup>
Ус хангамж	Төвийн шугам сүлжээнд холбогдсон
Бохирын шийдэл	
Цахилгаан хангамж	
Хог хаягдал	Энгийн хог хаягдлыг БГД-н ТҮК Аюултай хог хаягдал “Түмэн Эгшиг” ХХК, Ахуйн шингэн хаягдал УСУГ-тай тус тус гэрээтэй

## 1.2 Төслийн үйл ажиллагааны товч танилцуулга

Төсөл хэрэгжүүлэгч “Вейр Минералс Монголиа” ХХК нь 2017 оноос эхлэн уул уурхайн металл тоног төхөөрөмж, шугам хоолойн зэврэлт, элэгдэлт, химийн бодисын үйлчлэлийг тэсвэрлэх, бэхжилтийг сайжруулах, эдэлгээг удаашруулах зорилгоор металл хийцийг резинэн хуягаар доторлох үйлчилгээг үзүүлж байна. Тус компани нь жилд 1200 м<sup>2</sup> талбай бүхий шугам хоолойг хуяглах хүчин чадалтай.

Үйл ажиллагаа нь Улаанбаатар хотын Баянгол дүүргийн 29-р хороо, Ажилчдын гудамжид байрлах “Коммод” ХХК-ийн 1440 м<sup>2</sup> талбайтай үйлчилгээний байр болон 800 м<sup>2</sup> талбайтай агуулахыг 2018 оноос гэрээний үндсэн дээр түрээслэн явуулж байна.


Төслийн талбайн:

Баруун болон хойд талд: “Коммод” ХХК-ийн уул уурхайн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний цех болон сэлбэг хэрэгслийн агуулах

Урд талд: Хүнсний бараа, бүтээгдэхүүний импортын компани

Зүүн талд: “ТЭС” шатахуун түгээх станц (ШТС)

Төв замаас: Баруун тийш 100 метр орчим зайтай байрладаг



ЗУРАГ 1 Төслийн байршил (Эх сурвалж: Google Earth)

### 1.3 Ажиллах хүчин

Төсөл хэрэгжүүлэгч “Вейр Минералс Монголиа” ХХК нь нийт 26 ажилтантай үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

- Металл хийцийг резинэн хуягаар доторлох шугамын ажилтан
- Механик засвар үйлчилгээ хариуцсан ажилтан
- Менежер
- Ахлах ажилтан
- Санхүүгийн ажилтан
- ХАБЭА, Чанар болон Байгаль орчин хариуцсан мэргэжилтэн
- Бүс нутаг хариуцсан менежер

Засвар үйлчилгээний хэсэг нь 1 ээлжтэй, өдөрт 8 цаг, ажлын 5 хоногийн хуваариар ажилладаг.

#### ХҮСНЭГТ 1.2 ХҮНИЙ НӨӨЦ

№	Салбар	Албан Тушаал	Орон тоо, ш
1	Удирдлага	Бүс нутаг хариуцсан менежер	1
2	Худалдаа	Хэрэглэгч хариуцсан менежер	1
3		Борлуулалт, Төсөл хариуцсан менежер	2
4	Инженер	Сайтын инженер	2
5		Инженерийн Зураг, Төсөл хариуцсан инженер	1
6		ХАБЭА, ЧБО хариуцсан мэргэжилтэн	1
7	Ложистик, агуулах	Агуулахын нярав	1
8		Ложистикийн зохицуулагч	1
9	Санхүү	Санхүүгийн менежер	1
10		Татварын нягтлан	1
11		Санхүүгийн ажилтан	1
12	Засвар үйлчилгээ	Засвар Үйлчилгээний Төв хариуцсан менежер	1
13		Засвар Үйлчилгээний Төвийн зохицуулагч	1
14		Резин доторлогооны багийн ахлах	2
15		Резин доторлогоочин	6
16		Механикийн ахлах	1
17		Механик	1
18	Жолооч	Жолооч	1
НИЙТ			26

## 1.4 Төслийн технологи

Засвар үйлчилгээний төв нь шугам хоолой болон металл хийцийг доорх схемд үзүүлсэн технологийн аргаар хуягладаг.



## 1.5 Техник тоног төхөөрөмж

Төслийн талбайд ашиглагдаж буй техник, тоног төхөөрөмж

ХҮСНЭГТ 1.3 ТЕХНИК ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

Техник	Тоо, ширхэг
Өргөх, буулгах 5Т даацтай кран	1
Өргөх, буулгах 4Т даацтай вандан кран	1
Дизель хөдөлгүүрт 5Т сэрээт ачигч	1
Цахилгаан 1Т сэрээт ачигч	2
Туулах чадвар сайн суудлын автомашин	3

## 1.6 Түүхий эд материал

Төслийн үйл ажиллагаанд ашиглагдах туслах материалууд болох барьцалдуулагч цавуу, хурдан хатаагч бодис, металлыг зэврэлтээс хамгаалагч, резин дүүргэгч, шингэлэгч, угаагч зэрэг 16 төрлийн химийн бодисыг жилд нийт 10 тонн хэмжээгээр толгой компаниас импортоор авч ашиглана. Эдгээр бодисуудын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг дараах хүснэгтэд тусгасан болно.

ХҮСНЭГТ 1.4 ХИМИЙН БОДИСЫН НЭР ТОМЪЁО, ТОО ХЭМЖЭЭ

№	Монгол нэршил	Олон улсын нэршил	Химийн томъёо	CAS дугаар	Зөвшөөрөгд сөн хэмжээ, кг
1	Гадаргуу бэлтгэгч Солуфикс 30А	Ethyl acetate	$\text{CH}_3\text{COO}-\text{C}_2\text{H}_5$	141-78-6	2400
2	Резиний гадаргуу барзайлт тодосгогч, исэлдүүлэгч Солуфикс 30Б	Trichloroisocyanuric acid; Dichloroisocyanurate	$\text{C}_3\text{Cl}_3\text{N}_3\text{O}_3$ $\text{C}_3\text{HCl}_2\text{N}_3\text{O}_3$	141-78-6 9016-87-9 101-68-8	87.5
3	Хурдан хатаагч бодис Солуфикс 14Б	Ethyl acetate; Polymeric diphenylmethane diisocyanate; Diphenylmethane diisocyanate	$\text{CH}_3\text{COO}-\text{C}_2\text{H}_5$ $\text{C}_{15}\text{H}_{10}\text{N}_2\text{O}_2$	141-78-6 9016-87-9 101-68-8	1312.5
4	Цавууны бодис Солуфикс 14Т	Toluene; Methyl ethyl ketone	$\text{C}_6\text{H}_5\text{CH}_3$ $\text{C}_4\text{H}_8\text{O}$	108-88-3 78-93-3	4800
5	Цавууны бодис 14ТАС	Ethyl acetate; Cyclohexane	$\text{CH}_3\text{COO}-\text{C}_2\text{H}_5$ $\text{C}_6\text{H}_{12}$	141-78-6 110-82-7	4800
6	Металл гадаргууг зэврэлтээс хамгаалагч Кемлок 205	Methyl isobutyl ketone; Xylene; Titanium dioxide; Ethylbenzene; Propylene glycol monomethyl ether - alpha isomer; Carbon black	$\text{C}_6\text{H}_{12}\text{O}$ $\text{C}_8\text{H}_{10}$ $\text{TiO}_2$ $\text{C}_8\text{H}_{10}$ C	108-10-1 1330-20-7 13463-67-7 100-41-4 107-98-2 1333-86-4	1500
7	Шингэн резин дүүргэгч	Хамааралгүй	Хамааралгүй	Хамааралгүй	600
8	Элэгдлээс хамгаалах түрхлэг Веарстоп А	Bisphenol A/ diglycidyl ether polymer, high molecular weight; (C12-14)alkyl glycidyl ether	$(\text{C}_{15}\text{H}_{16}\text{O}_2-\text{C}_3\text{H}_5\text{ClO})_x$	25068-38-6 68609-97-2	3600
9	Хурдасгуур хатаагч Веарстоп Б	Diethylenetriamine; •Bisphenol A		111-40-0 80-05-7	3600
10	Цавууны бодис Солуфикс 10Т	Toluene •Carbon Black	$\text{C}_6\text{H}_5\text{CH}_3$ C	108-88-3 (90-94%) 1333-86-4 (1-2%)	1000

11	Гадаргуу бэлтгэгч Лина 885А	Хамааралгүй	Хамааралгүй	Хамааралгүй	10500
12	Бохирдол цэвэрлэх угаагч, гадаргуу бэлтгэгч Лина 885Б	potassium peroxymonosulfate sulfate chlorine sulfuric acid	$H_3K_5O_{18}S_4$ $Cl_2$ $H_2SO_4$	70693-62-8 7782-50-5 7664-93-9	11400
13	Цавууны бодис Лина 888А	4,4'-methylenebis(N- sec-butyl)aniline bis[3- (trimethoxysilyl)propyl] amine	$C_{21}H_{30}N_2$ $C_{12}H_{31}NO_6Si_2$	5285-60-9 82985-35-1	4200
14	Хурдан хатаагч бодис Лина 888Б	4,4'-diphenylmethane diisocyanate (MDI) MDI oligomer 2,4'-diphenylmethane diisocyanate p- toluenesulfonyl isocyanate 2,2'-diphenylmethane diisocyanate	$C_{15}H_{10}N_2O_2$ $CH_3C_6H_4SO_2NC$ $O$ $C_{15}H_{10}N_2O_2$	101-68-8 9016-87-9 5873-54-1 4083-64-1 2336-05-2	2100
15	Металл гадаргууг зэврэлтээс хамгаалагч	Хамааралгүй	Хамааралгүй	Хамааралгүй	1500
16	Шингэлэгч Толуол	Toluene	$\bullet C_6H_5CH_3$	108-88-3	2400

Эдгээр бодисууд нь Засгийн газрын 2007 оны 95 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол Улсад ашиглахыг хориглосон болон хязгаарласан химийн хорт болон аюултай бодисын жагсаалт”-д, мөн Олон улсын гэрээ, конвенцүүд болох Удаан задардаг органик бохирдуулагчдын тухай “Стокгольмын конвенци”, Зарим аюултай химийн бодис, пестицидийг олон улсын хэмжээнд худалдаалахтай холбоотой урьдчилан мэдээлж, зөвшилцөх журмын тухай “Роттердамын конвенци”, Озоны үе давхаргыг хамгаалах тухай “Венийн конвенци”-ийн хориглосон болон хязгаарласан заалтад хамаарахгүй болно.

## 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Улаанбаатар хот нь Монгол орны физик-газарзүйн мужлалаар Хангай-Хэнтийн уулархаг их мужийн Хэнтийн мужийн баруун хэсэгт, Хэнтийн нурууны шувтрах үзүүр болох Асралт хайрхан (2799 м) уулын өвөрт, Богдхан уулын ар хормойд, Туул голын сав газарт оршдог. Хот нь Чингэлтэй уул (1949 м), Баянзүрх уул (1834 м), Богдхан уул (2256 м), Сонгинохайрхан уул (1652 м) зэрэг уулсаар хүрээлэгдсэн. Улаанбаатар хотын барилгажсан болон барилгажих талбай нь далайн түвшнээс дээш 1260–1350 м өндөрт байрлах бөгөөд газрын гадаргуу нь хойд уулсаас Туул голын сав хөндий рүү чиглэсэн налуу тогтолцоотой юм.

Төслийн байршил нь физик-газарзүйн мужлалаар Хангай-Хэнтийн уулархаг их муж (III)-ийн баруун өмнөд хэсэгт, Хэнтийн уулархаг дэд муж (III2), Хэнтийн захын уулсын тойрогт хамаарна. Ландшафтын хувьд Хэнтийн уулт өндөрлөгийн төв хэсгийн тайга, ян сарьдаг бүхий дэд муж (III3б)-д багтдаг. Байгалийн бүс бүслүүрээр ойт хээрийн бүсэд, Улаанбаатарын ойт хээр, умардын хуурай хээр, тайгын бүсийн заагт, далайн түвшнээс дээш 1282 м өндөрт оршдог.

Энэ бүс нутагт олон жилийн цэвдэгтэй чулуулаг алаг цоог тархсан бөгөөд 1500–1600 метрээс дээш үнэмлэхүй өндөртэй уулсын ар, сүүдэр тал, намгархаг болон чийг ихтэй орчин давамгайлдаг.

Уур амьсгалын хувьд хуурайдуу, сэрүүн зунтай, хахир өвөлтэй, нэн хүйтэн бүсийн дэд мужид хамаарна. Агаарын температурын олон жилийн дундаж нь  $-1.3^{\circ}\text{C}$ . Хамгийн хүйтэн сарууд болох 12, 1-р сарын дундаж температур  $-25^{\circ}\text{C}$ ,  $-30^{\circ}\text{C}$ , үнэмлэхүй бага температур  $-40.5^{\circ}\text{C}$  хүрдэг. Агаарын харьцангуй чийгшил жилд дунджаар 62% бөгөөд 12, 1-р сард 70–74%, 7-р сард 48% байдаг. Цасан бүрхүүлийн зузаан 2–7 см, хамгийн зузаан нь дунджаар 13–20 см, нягт нь 0.12–0.21 г/см<sup>3</sup> хооронд хэлбэлздэг. Хот орчимд жилд дунджаар 2791.5 цаг нар гийгүүлдэг. Салхины жилийн дундаж хурд 2.3 м/сек бөгөөд гол төлөв баруун хойд болон хойд зүгийн салхи зонхилно. Жилийн салхины 53.6% нь 0–2 м/сек, 12.5% нь 6–10 м/сек, 1.3% нь 11–15 м/сек, 0.4% нь 15 м/сек-ээс дээш хурдтай байна. Хөрсний гадаргын жилийн дундаж температур ойролцоогоор  $-0.8^{\circ}\text{C}$  бөгөөд зуны улиралд хоногийн дундаж температур  $36^{\circ}\text{C}$  хүртэл халж, өвлийн улиралд  $-39^{\circ}\text{C}$  хүрч хүйтэрдэг.

Төслийн байршил орчмын газрын гадарга нь хотжилтын нөлөөгөөр бүрэн өөрчлөгдөж, байгалийн ургамлын нөмрөг болон хөрсний бүрхэвч устсан байна.

Байгаль орчны төлөв байдлын 2022 онд хийгдсэн судалгааны ажлын хүрээнд хийсэн орчны шинжилгээний дүнгүүдийг холбогдох стандартуудтай харьцуулахад “Хүрээлэн буй орчин – Эрүүл мэндийг хамгаалах – Аюулгүй байдал – Ундны ус – Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ” (MNS 0900:2005), “Хөрсний чанар – Хөрсөнд агуулагдах бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ” (MNS 5850:2019) стандартуудын шаардлагыг хангаж байсан болно.

### 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

#### ХҮСНЭГТ 3.1 Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, арга хэмжээ

Сөрөг нөлөөл	Сөрөг нөлөөллийн эх үүсвэр	Урьдчилан сэргийлэх арга хэмжээ	Бууруулах, арилгах арга хэмжээ
Болзошгүй	Химийн бодисын сав баглаа, боодол	<ul style="list-style-type: none"> <li>Хог хаягдлыг ил задгай хаяхгүй байх, эмх цэгцтэй хураах, зориулалтын саванд хуримтлуулж хадгалах</li> <li>Химийн бодисын сав, баглаа боодлыг тусад нь ангилан хадгалах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Дахин ашиглах боломжгүй хаягдлыг түр хогийн цэгт хуримтлуулж, нийлүүлэгчид буцаан өгнө</li> </ul>
	Химийн бодисуудын хоруу чанар	<ul style="list-style-type: none"> <li>Бодисуудыг хор аюулын лавлах мэдээлэлд заасан нөхцөлд хадгалах, түүний дагуу харьцаж ажиллах</li> <li>Химийн бодисыг хөрсөнд ил задгай асгахгүй байх</li> <li>Аюултай бодисуудыг гал, дөл, оч үсрэх эх үүсвэрээс тусгаарлан хадгалах орчныг бүрдүүлж, механик цохилт, үрэлт, халалт зэрэг эрсдэлээс хамгаалан хадгалах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Бодис, бүтээгдэхүүнийг тусгай зориулалтын өрөөнд хадгалах</li> <li>Агуулахуудыг гал унтраах багаж хэрэгслээр тоноглож, тэдгээрийн бэлэн байдлыг тогтмол хангах</li> <li>Химийн бодисыг анхааруулах тэмдэг, дохио үг бүхий тэмдэглэгээгээр тэмдэглэх</li> <li>Эрсдэл тохиолдсон үед эмнэлгийн яаралтай тусламж авах нөхцөлийг бүрдүүлэх</li> <li>Асгарсан бодисыг яаралтай цуглуулж, саармагжуулан, зохих журмын дагуу устгах</li> </ul>
	Ажлын байрны нөхцөл, аюулгүй ажиллагаа, осол эрсдэл	<ul style="list-style-type: none"> <li>Ажиллагсад болзошгүй осол, эрсдэл үүссэн тохиолдолд авах арга хэмжээг түргэн шуурхай хэрэгжүүлж, анхны тусламж үзүүлэх, осол эрсдэлийг бууруулах, арилгах талаар зохих мэдлэгтэй байна</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Болзошгүй осол, эрсдэлээс ямагт урьдчилан сэргийлж, анхаарал болгоомжтой ажиллах</li> <li>Анхааруулах болон хориглох тэмдэг, тэмдэглэгээг байрлуулах</li> <li>Мөн эрсдэл тохиолдсон үед хэрэглэх хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэглэл, гал унтраах багаж хэрэгслийг бэлэн байлгах</li> </ul>
	Бүрэн бус техник хэрэгсэл	<ul style="list-style-type: none"> <li>Техник хэрэгсэлтэй ажиллах үед хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгааг өдөр бүр өгч, хэрэгжилтэд нь тогтмол хяналт тавих</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Техник хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг тогтмол шалгаж, хэвийн ажиллагааг хангах</li> </ul>
	Мэргэжлээс шалтгаалах өвчлөл	<ul style="list-style-type: none"> <li>Ажилчдыг жил бүр эмнэлгийн нарийн мэргэжлийн үзлэгт тогтмол хамруулах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Анхны тусламжийн хэрэгслийг зохих байршилд байрлуулах</li> <li>Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг тогтмол хийлгэх</li> </ul>
	Цахилгаан, эрчим хүчний хэт их хэрэглээ	<ul style="list-style-type: none"> <li>Хэрэглээгүй үед цахилгаан тоног төхөөрөмжийг унтрааж хэвших</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Эрчим хүчний хэмнэлттэй тоног төхөөрөмж, цахилгаан хэрэгслийг сонгон ашиглах</li> </ul>
	Байгалийн гамшигт үзэгдэл	<ul style="list-style-type: none"> <li>Болзошгүй осол, эрсдэлээс ямагт урьдчилан сэргийлж, анхаарал болгоомжтой ажиллах, байнгын бэлтгэлтэй байхыг хэвшүүлэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Гал унтраах багаж хэрэгслийг шууд хүрч болохуйц, хүртээмжтэй байршилд бэлэн байлгах</li> </ul>

**ХҮСНЭГТ 3.2 Болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ**

Үйл ажиллагаа	Болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ
Бодисын хадгалалт	<ul style="list-style-type: none"> <li>▪ Бодис, бүтээгдэхүүнийг тусгай өрөө, агуулахад Хор аюулын лавлах мэдээлэлд заасан нөхцөлд хадгална</li> <li>▪ Бодисыг хүний нүдний түвшингээс дээш тавиур дээр байрлуулахыг хориглоно. Тавиур нь гулсаж унахаас хамгаалсан хаалт, саадтай байна</li> <li>▪ Шалан дээр хурааж хадгалах тохиолдолд хүн явах зам гаргаж, гарцыг хааж болохгүй</li> <li>▪ Шингэн бодисыг хагардаггүй эсвэл бат бөх давхар савлагаатай саванд хадгална. Хадгалах агуулахын температур нь тухайн бодисын хадгалах нөхцөлд тохирсон байна</li> <li>▪ Асгарсан, гоожсон эсвэл эвдэрхий сав, баглаатай бодисыг хадгалахыг хориглоно. Асгарсан бодисыг цэвэр, бүтэн саванд шилжүүлж, орчныг цэвэрлэнэ</li> <li>▪ Агуулах нь гаднын хүн нэвтрэх боломжгүй, хаалт, цоожтой байна</li> <li>▪ Хадгалж буй бодисын ангилал, нэр төрөл, тоо хэмжээ бүхий байнгын бүртгэлтэй байна</li> <li>▪ Агуулахад хүнсний зүйл хадгалах, хэрэглэхийг хориглоно</li> <li>▪ Аюул, ослын үед гарах аврах гарц болон гал унтраах багаж хэрэгслийг хааж бодис бүтээгдэхүүнийг хурааж, өрөхийг хориглоно</li> </ul>
Бодис бүтээгдэхүний ашиглалт	<ul style="list-style-type: none"> <li>▪ Ашиглаж буй химийн бодисын хор, аюулын шинж чанарыг илтгэх анхааруулга, дохио үг, аюулын тэмдэглэгээг ажлын байранд тод, харагдахуйц байрлалд байршуулсан байна</li> <li>▪ Химийн бодистой харьцаж ажиллахдаа гэрээт байгууллагын мэргэжлийн зөвлөгөө, зөвлөмжийн дагуу ажиллах бөгөөд тухайн чиглэлээр сургалтанд хамрагдсан ажилтан ажиллана</li> <li>▪ Ажилтнуудыг жилд нэг удаа эмнэлгийн үзлэгт хамруулна</li> <li>▪ Агуулахын өрөөний гэрэлтүүлгийг сайжруулж ЛЕД гэрэлтүүлэгтэй болгоно</li> <li>▪ Мөн ажлын байрны ариун цэврийн нөхцлийг хангаж, үйлдвэрлэлийн зохистой дадал (GMP)-ыг хэрэгжүүлэн ажиллана</li> </ul>
Бодисын савыг цуглуулах, хадгалах	<ul style="list-style-type: none"> <li>▪ Химийн бодисын сав, хаягдлыг байгаль орчныг бохирдуулахаас сэргийлсэн тусгай зориулалтын хогийн цэгт хаяна</li> <li>▪ Химийн бодисын сав, хаягдлыг талбайд түр хадгалах эсвэл нийлүүлэгчид буцаан өгнө</li> </ul>
Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа	<ul style="list-style-type: none"> <li>▪ Ажилтан, албан хаагчдад хэрэглэж буй химийн бодисын талаар мэдлэг, мэдээлэл олгох сургалтыг зохион байгуулна</li> <li>▪ Химийн бодист хордсон зэрэг гэнэтийн ослын үед яаралтай тусламжийн заавар, зөвлөмжийг тухай бүрт нь өгч ажиллана</li> <li>▪ Ажилтнуудыг хөдөлмөр хамгааллын хувцас, хамгаалах хэрэгслээр бүрэн хангаж, тэдгээрийн бүрэн бүтэн байдал болон хэрэглээг тогтмол хянана</li> <li>▪ Гэнэтийн аваар, ослын үед яаралтай холбоо барих утасны жагсаалтыг бэлэн байлгана</li> <li>▪ Харьяа орон нутгийн Онцгой байдлын газарт бүртгүүлж, гэнэтийн ослын үед тусламжийг цаг алдалгүй авах нөхцөлийг бүрдүүлнэ</li> <li>▪ Болзошгүй сөрөг үйл явц, түүний шалтгааныг үүсгэхээс сэргийлэх зорилгоор ажилтнуудад хувь хүний үүрэг, хариуцлагыг ухамсарлуулах байнгын сургалт, сурталчилгааг (хор аюулын зураг, бичлэг хэлбэрээр) зохион байгуулна</li> </ul>

## 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

### Зорилго

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-ний гол зорилго нь төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин болон хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, тэдгээр нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг төлөвлөхөд оршино. Энэ хүрээнд төлөвлөж буй арга хэмжээ бүр нь төсөл хэрэгжүүлэгчийн хэрэгжүүлж чадахуйц, бодитой байх нь чухал юм.

### Гол зорилтууд

Байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд, хүний эрүүл мэнд, нийгэм, эдийн засагт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, эрсдлээс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулахад зайлшгүй хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөнө.

Төслийн үйл ажиллагаанаас агаар, хөрс, усны орчин болон ажлын байрны нөхцөлд үзүүлэх нөлөөллийг тодорхойлох, хяналт шинжилгээ хийх арга хэмжээг төлөвлөнө.

2026 онд хэрэгжүүлэх БОМТ-г Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/618 тоот тушаалын хавсралтаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсруулсан болно.

Төслийн үйл ажиллагааны онцлог, байршлаас хамааран дараах дэд төлөвлөгөөнүүд БОМТ-д тусгагдаагүй болно. Үүнд:

- Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө
- Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө
- Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө
- Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө
- Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Энэхүү БОМТ-нд төсөл сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, химийн бодис болон осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө, БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөр-ийн нийт 31 ажил багтсан бөгөөд төслийн 2026 оны менежментийн төлөвлөгөөний ажилд нийт 3.9 сая.төг зарцуулахаар төлөвлөв.

Төсөл хэрэгжүүлэгч нь жил бүрийн 11 дүгээр сарын 1-ний дотор тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний (БОМТ) биелэлтийн тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу боловсруулж тайлагнах үүрэгтэй. Мөн дараа оны БОМТ-г 12 дугаар сарын 31-ний дотор холбогдох байгууллагад хүргүүлэх үүрэгтэй.

## 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Хөрсөн бүрхэвчид сөргөөр нөлөөлөх	Эзэмшил ашиглалтад байгаа болон түүний орчны 50м хүртлэх нийтийн эзэмшлийн зам талбай арчилгаа хийх	Эзэмшил газар, түүний ойр орчим	-	Үйл ажиллагааны зардалд тусгах			Жилд 2 удаа	“Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль”-ийн 7.2.4, НЗДын 2013 оны А/623 дугаар захирамж, Газар эзэмшүүлэх гэрээний 4.19
2		Эзэмшил талбай дотор ил задгай хог хаягдлыг цэвэрлэх, дахин үүсгэхгүй байх		-				Жилд 2 удаа	“Эрүүл ахуйн тухай хууль”-ийн 4.4.3, “Хог хаягдлын тухай хууль”-ийн 9.2.2, 9.4.8
3	Машин механизмаас ялгарах хорт утаа агаарын чанарт сөргөөр нөлөөлөх	Машин техникийг үзлэгт хамруулах, агаарын бохирдлын төлбөрийг төлөх	Эзэмшил газар	-	Үйл ажиллагааны зардалд тусгах			Жилд 1 удаа	MNS 5885-2008 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага

## 6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
	1	2	3	4	5	6	7	8
1	Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлагаар зохион байгуулагдах "Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд мод тарих	Мод тарих	Налайх Дүүрэг, 3р хороо, Их бага модны ам	Ширхэг	55	55,000₮	3,025,000₮	2-р улиралд
2	Эзэмшил талбайд байгаа модны усалгаа аричилгааг тогтмол хийх	Арчилгаа, усалгаа		Ширхэг	55			3 жилийн хугацаанд
Нийт					3,025,000₮			

## 7. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Химийн бодистой харьцаж буй ажилтан осолд өртөх, байгаль орчинд сөргөөр нөлөөлөл үзүүлэх	Химийн бодистой харьцаж ажиллагсадыг химийн бодистой аюулгүй харьцаж ажиллах сургалт, дадлагад хамруулах	Химийн бодистой харьцаж ажиллагсад	12	Үйл ажиллагааны зардалд тусгах		Жилд 2 удаа	“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль”-ийн 8.1.2, 12 дугаар зүйл, “Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль”-ийн 13.6.
2	Өндөр эрсдэлтэй ажил гүйцэтгэдэг ажилтан осолд өртөх	Ажилтнуудыг зохих өндөр эрсдэлтэй ажлын дадлагажуулах сургалтад хамруулах	Өндөр эрсдэлтэй ажил гүйцэтгэдэг ажиллагсад	-	Үйл ажиллагааны зардалд тусгах		Жилд 1 удаа	“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль”-ийн 17-р зүйл Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын А/173 дугаар тушаал
3	Ажилтны эрүүл мэнд, амь нас болон төслийн талбай орчмын хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөлөл үүсэх	Болзошгүй аюул, эрсдэлийг цаг тухайд нь илрүүлэн, судлах	Төслийн талбай		Үйл ажиллагааны зардалд тусгах	Үйл ажиллагааны цар хүрээнд		“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль”-ийн 27-р зүйл ҮОХХ-н судлан бүртгэх дүрэм

## 8. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Ахуйн	Ажилчдаас гарах хатуу хаягдлыг зориулалтын цэгт байршуулж цуглуулан нэгдсэн хогийн цэгт зөөвөрлөн хаяна	Төслийн талбай					Тогтмол	Хог хаягдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/ Хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, эргүүлэн ашиглах, устгах журам
2		Ахуйн хог, хаягдлыг түр хадгалах зориулалтаар дахин ашиглагдахгүй байдлаар нь ангилан хадгалах							
3	Аюултай	Үйлдвэрлэлээс үүсэх аюултай, хортой хог хаягдлыг зориулалтын цэгт, стандартын дагуу нэгтгэж тусгай зөвшөөрөлтэй компанид гэрээний дагуу хүлээлгэн өгөх	Төслийн талбай					Тогтмол	Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль 8.1, 14.1

## 9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
	1	2	3	4	5	6	7	8
1	Агаар	Төслийн талбайд	Жилд 1 удаа	1	Үйл ажиллагааны зардалд		1. ЦУОШГ-н агаарын чанарын мэдээ – Монгол газар станц 2. Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ	MNS 4585: 2016  ISO/IEC 17020:2013 MNS 5080:2023
2	Усан орчин				725,000	725,000	Усны ерөнхий үзүүлэлт Усны микробиологийн шинжилгээ	MNS 0900:2018
3	Хөрс				150,000	150,000	Хүнд метал	MNS 3298:1991
Нийт					875,000			

## 10. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ

Улаанбаатар хотын Баянгол дүүрэг 29-р хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй “Вейрминералс монголиа” ХХК нь 2025 оны БОМТ-ний хэрэгжилтийн талаар БОУАӨЯ болон Нийслэлийн Байгаль орчны газарт тайланг цахимаар хүргүүлнэ.

### ХҮСНЭГТ 7. БОМТ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ХУВААРЬ

№	Тайлагнах, хэлэлцүүлэх байгууллага	Тайлагнах хэлбэр	Мэдээний агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах хэлбэр
1	Нийслэлийн байгаль орчны газар	БОМТ тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, танилцуулах	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тухай	2025 оны 11 сарын 31-ний дотор	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнаж, дүгнэлт гаргуулах	Цахим эсвэл биеэр (тухайн үеийн санал болгож буй хэлбэрээр)

## 11. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд 2026 онд нийт 3,900,000 (гурван сая есөн зуун мянга) төгрөг зарцуулна.

### ХҮСНЭГТ 8. 2025 ОНЫ БОМТ-НИЙ НИЙТ ЗАРДАЛ

№	Зардлын хэлбэр	Зардал, төгрөг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний зардал	Үйл ажиллагааны зардлаар
2	Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	3,025,000
3	Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
4	Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөөний зардал	Үйл ажиллагааны зардлаар
5	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардал	Үйл ажиллагааны зардлаар
6	Орчны хяналт шинжилгээний зардал	875,000 ₮
<b>Нийт</b>		<b>3,900,000</b>

